



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2016 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Төлбөрийн тэнцэл

2016 оны 3-р улиралд (7-9 сар) урсгал данс 117 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 129 сая ам.долларын алдагдалтай, нийт төлбөрийн тэнцэл 186 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурчээ. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 59 сая ам.доллар байна.

2015 оны 3-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 57 сая ам.доллараар буурсан бол хөрөнгө ба санхүүгийн данс 220 сая ам.доллараар буурч 129 сая ам.долларын алдагдалтай байна. Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,092.4 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 4.1 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Гадаад хөрөнгө оруулалтын позиц (ИР)

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,743 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 29,906 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц 2016 оны 3-р улирлын байдлаар 26,164 сая ам.долларын сөрөг үлдэгдэлтэй буюу богино позицтой байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулах бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 7% буюу 1676 сая ам.доллараар өссөн.

Үүнд, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 17 сая ам.доллараар өсч, шууд хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө оруулалт болон гадаад валютын улсын нөөц 9 сая ам.доллар, 37 сая ам.доллар, 204 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц




Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл тайлант улирлын эцэст 23,785 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10%-иар буюу 2,195 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрийн гадаад өр 34%-иар буюу 1217 сая ам.доллараар өсч 4,759 сая ам.долларт,
- Төв банкны гадаад өглөг 22%-иар буюу 482 сая ам.доллараар буурч 1,729 сая ам.долларт,
- Банкуудын гадаад өр 27%-иар буюу 495 сая ам.доллараар өсч 2,351 сая ам.долларт,
- Бусад сектор (ААН)-ын гадаад өр 132%-иар буюу 4486 сая ам.доллараар өсч 8,128 сая ам.долларт,
- Гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эх үүсвэр 35%-иар буюу 3654 сая ам.доллараар буурч 6,817 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Гадаад секторын статистик

Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг. Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.

Дүрслэл 4. Статистик хамаарал



I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

УРСГАЛ ДАНС

2016 оны 3-р улиралд урсгал тэнцлийн алдагдал 117 сая ам.долларт хүрч, алдагдлын хэмжээ 2015 оны мөн үеэс 33%-иар буурчээ.

Өнгөрсөн оны мөн үед ашигтай гарч байсан бараа, үйлчилгээний худалдаа энэ улиралд 54 сая ам.долларын алдагдалтай гарав. Тайлант хугацаанд барааны дансны ашиг 6 сая ам.доллараар өссөн хэдий ч үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 95 сая ам.доллараар өссөн нь ашиг буурахад нөлөөлжээ.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 6%-иар буурч 2,068 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд 103 сая ам.долларт хүрч, сүүлийн 9 улирал дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад тайлант улиралд нефтийн импорт 21%-иар, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 4%-иар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин өнгөрсөн он болон 2016 оны 1 дүгээр улиралд бууралттай байсан хэрэглээний барааны импорт тайлант хугацаанд 19%-иар өссөн байна.

Үйлчилгээний худалдаа

Тайлант улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны 3-р улирлын гүйцэтгэлээс 94 сая ам.доллараар өсч 158 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 93 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ. Бусад үйлчилгээний зардал өсөхөд санхүүгийн, барилгын, архитектур, инженер болон техникийн үйлчилгээний өсөлт голлон нөлөөлжээ.

Орлого

2016 оны 3-р улирлын гүйцэтгэлээр орлогын данс 141 сая ам.долларын алдагдалтай гарч 2015 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 44%-иар буюу 110 сая ам.доллараар буурсан. Тайлант хугацааны голлох төлбөрийг дурьдвал:

- ААНБ-ууд гадаадын хөрөнгө оруулагчдад 37 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, хөрөнгө оруулагчдын зээлийн үүсвэрт 55 сая ам.долларын хүү төлсөн,
- Монгол Улсын Засгийн газар бонд, гадаад зээлийн эх үүсвэрт 35 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- ААНБ-ууд бусад гадаад зээлийн эх үүсвэрт 39 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Банкууд гадаад зээл болон харьяат бусын харилцах, хадгаламжийн дансанд 27 сая ам.долларын хүүгийн төлбөр төлсөн,
- Төр, хувийн хэвшил хамтдаа бондын эх үүсвэрт 44 сая долларын хүүгийн төлбөрийг төлсөн байна.


Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 0.5%-иар буурсантай зэрэгцэн гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 30%-иар буурснаар ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 35 сая ам.доллар болж өссөн байна.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	III улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
I. Урсгал тэнцэл	-173	-117	57	33%
A. Бараа, үйлчилгээний худалдаа	34	-54	-88	-258%
а. Бараа	98	104	6	6%
б. Үйлчилгээ	-63	-158	-95	-149%
B. Цэвэр орлого	-250	-141	110	44%
V. Урсгал шилжүүлэг	42	78	36	84%

Дүрслэл 5. Барааны худалдаа



Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	20,988	38% ▲	49%	1,678	8% ▼	-17%
Америк	9,746	18% ▲	25%	2,986	15% ▼	-53%
Хятад	2,080	4% ▼	-55%	3,410	17% ▼	-43%
Гонг Конг	977	2% ▼	-55%	332	2% ▼	-26%
Англи	2,647	5% ▼	-28%	709	3% ▼	-16%
ОХУ	1,255	2% ▼	-29%	2,193	11% ▲	70%
Сингапур	869	2% ▼	-39%	587	3% ▲	75%
Швейцарь	1,418	3% ▼	-14%	99	0% ▼	-92%
Герман	1,957	4% ▼	-23%	967	5% ▲	29%
Япон	1,957	4% ▲	23%	583	3% ▼	-4%
Бусад	11,506	21% ▼	-20%	6,959	34% ▼	-26%
НИЙТ	55,400	100%		20,503	100%	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (жилээр, сая ам.доллар)

	III улирал			Өөрчлөлт	
	2014	2015	2016	Мөнгөн дүн	Хувиар
Ажилчдын гуйвуулга (цэвэр)	7.7	26.4	34.9	8.5	32.2%
Гаднаас орж ирсэн	52.8	55.7	55.4	-0.3	-0.5%
Гадагш шилжүүлсэн	-45.1	-29.3	-20.5	8.80	-30.0%

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 129 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 220 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Энэ нь банкны салбарын харилцах хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 725 сая ам.доллараар буурснаас голлон шалтгаалж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2016 оны 3-р улиралд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 60 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 88 сая ам.доллараар өссөн байна.

Үүнд, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн оны түвшнээс 89 сая ам.доллараар өсч, 60 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Тайлант улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар нь авч үзвэл, Австрали улсаас манай улсад оруулсан хөрөнгө оруулалт 2015 оны 3 дугаар улиралд -52.9 сая ам.доллар буюу хөрөнгө оруулалтаа буцаан татсан үзүүлэлттэй байсан бол 2016 оны 9 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 65.0 сая ам.доллараар өсч 12.1 сая ам.долларт, БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 2015 онд 1.8 сая ам.доллар байсан бол 2016 оны 3 дугаар улиралд 47.7 сая ам.доллараар өсч -45.6 сая ам.долларт хүрсэн бол Голланд улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 39.9 сая ам.доллараар буурч -36.3 сая ам.долларт, Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 20.4 сая ам.доллараар буурч -24.4 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Эдийн засгийн салбараар нь авч үзвэл 2016 оны 3 дугаар улиралд манай улсад орсон нийт хөрөнгө оруулалтын өсөлтийн 44%-ыг буюу 32.7 сая ам.долларыг барилгын салбарт оруулсан хөрөнгө оруулалт, 31% буюу 23.3 сая ам.долларыг бөөний болон жижиглэн худалдааны салбарт оруулсан хөрөнгө оруулалтууд тус тус эзэлж байгаа бол нийт бууралтын 43%-ыг буюу -32 сая ам.долларыг уул уурхайн салбараас буцаан татсан хөрөнгө оруулалт эзэлж байна.

Эдийн засгийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 135.9 сая ам.доллар, бөөний болон жижиглэнгийн худалдаа 11.7 сая ам.доллар, барилга 9.0 сая ам.доллараар тус тус өссөн бол зочид буудал, байр, сууц 38.3 сая ам.доллар, боловсруулах үйлдвэр 5.4 сая ам.доллар, цул хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 4.2 сая ам.доллар, бусад салбар 5.7 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 4 сая ам.долларын ашигтай гарчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 320 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Бусад хөрөнгө оруулалт

Тайлант онд бусад хөрөнгө оруулалтын данс 220 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тэнцэл 621 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	III улирал		өөрчлөлт	
	2015	2016	Дүн	Хувь
II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл	91	-129	-220	241%
<i>A. Хөрөнгийн данс</i>	35	27	-8	-24%
<i>B. Санхүүгийн данс</i>	56	-155	-211	-377%
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>				
<i>Гадаагш хийсэн</i>	0	0	0	-458%
<i>Монгол Улсад орсон</i>	-28	60	88	312%
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	-316	4	320	101%
<i>в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</i>	0	1	1	280%
<i>г. Бусад хөрөнгө оруулалт</i>	400	-220	-621	-155%
Үүнээс: Худалдааны зээл	-81	-69	12	15%
Бэлэн мөнгө харилцах	313	-412	-725	-2

Хүснэгт 5. ГШХО, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	III улирал		2016.III/15.III	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	12.1	16%	65.0	▲
2	Америк	9.9	13%	11.5	▲
3	Англи	0.2	0%	1.8	▲
4	Арабын Эмират	2.2	3%	2.3	▲
5	БНХАУ	45.6	62%	47.4	▲
6	Герман	12.2	16%	12.2	▲
7	Голланд	-36.3	-49%	-39.9	▼
8	Гонг-Конг	9.9	13%	-19.8	▼
9	Канад	14.9	20%	15.5	▲
10	Люксембург	-6.8	-9%	-6.8	▼
11	Малайз	-2.3	-3%	-2.5	▼
12	ОХУ	2.7	4%	0.5	▲
13	Сингапур	-26.4	-36%	-20.4	▼
14	Солонгос (өмнөд)	-11.5	-16%	-10.9	▼
15	Финлянд	0.0	0%	0.0	▼
16	Франц	6.6	9%	8.9	▲
17	Япон	31.6	43%	28.2	▲
18	Бусад	9.4	13%	10.8	▲
	Нийт	74.0	100%	103.8	▲

Хүснэгт 6. ГШХО, ЭЗ-ийн салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	III улирал		2016.III/15.III	
		2015	2016	Өөрчлөлт	
1	Барилга	23.7	32.7	9.0	▲
2	Боловсрол	0.8	0.5	-0.2	▼
3	Боловсруулах үйлдвэрлэл	8.9	3.5	-5.4	▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	11.6	23.3	11.7	▲
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	34.6	-3.7	-38.3	▼
6	Мэдээлэл, холбоо	12.3	9.6	-2.7	▼
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	9.8	14.7	4.9	▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	10.1	7.4	-2.7	▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	6.4	3.6	-2.8	▼
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7.7	4.6	-3.0	▼
11	Уул уурхай, олборлолт	-167.9	-32.0	135.9	▲
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.1	3.4	3.3	▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9.0	4.9	-4.2	▼
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.7	1.1	0.4	▲
15	Бусад	2.4	-3.2	-5.7	▼
	Нийт	-29.8	74.0	103.8	▲

Алдаа ба орхигдуулга

2016 оны 3 дугаар улиралд алдаа ба орхигдуулга үзүүлэлт 59 сая ам.доллар гарсан байна.

Уг үзүүлэлт эерэг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд дотогш чиглэсэн хөрөнгийн урсгал дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.

II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2016 оны 3-р улирлын эцэст -26,163.8 сая ам.доллар байв. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 26.6 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, багцын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа ГШХО-тай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчаасаа татсан зээлийн санхүүжилтийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,742.5 сая ам.доллар байна. Үүний 51%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 29%-ийг гадаад валютын албан нөөц, 10%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 9%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад Гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 29,906.3 сая ам.доллар хүрчээ. Үүний 43%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 45%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 46%-ийг буюу 5,921.1 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 54% буюу 6,817.3 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх улирлаас 0.9%-иар буюу 232.9 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 4.5%-иар буюу 162.9 сая ам.доллараар, гадаад пассив 1.3%-иар буюу 395.8 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 0.1%-иар буюу 8.6 сая ам.доллараар өссөнөөр, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 0.3%-иар буюу 36.8 сая ам.доллараар өссөнөөр, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 0.5%-иар буюу 16.6 сая ам.доллараар, гадаад валютын албан нөөц 15.8%-иар буюу 204.2 сая ам.доллараар тус тус буурснаар тайлбарлагдаж байна.


Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 54.2 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 61.3 сая ам.доллараар, бусад өөрчлөлтөөр -430.0 сая ам.доллараар, ханшийн зөрүүгээр 77.1 сая ам.доллараар өөрчлөгдсөнөөр тайлбарлаж байна.

Гадаад активын дүн буурч байгаа нь гадаад валютын улсын нөөцийн бууралтаас шалтгаалсан бол гадаад пассив өсөлт нь бусад хөрөнгө оруулалтын тодруулбал ААН-үүд болон Хөгжлийн банкны гадаад зээлийн эх үүсвэрийн өсөлтөөр голлон тайлбарлагдаж байна.


Хүснэгт 7. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	9/30/2015	9/30/2016	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-24,488	-26,164	1,676	7%
I. Гадаад актив	3,240	3,742	502	15%
1. Шууд хөрөнгө оруулалт	376	326	-50	-13%
2. Багцын хөрөнгө оруулалт	251	254	3	1%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	13	16	3	24%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,188	1,924	736	62%
5. Нөөц актив	1,413	1,092	-320	-23%
II. Гадаад пассив	27,728	29,906	2,178	8%
1. Шууд хөрөнгө оруулалт	16,512	12,738	-3,774	-23%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,043	3,690	646	21%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	21	5	29%
4. Бусад хөрөнгө оруулалт	8,157	13,458	5,300	65%

Дүрслэл 7. Гадаад актив



Дүрслэл 8. Гадаад пассив



Багцын хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад актив 2016 оны 3-р улирлын эцэст 325.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 30%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 3,689.6 сая ам.долларт хүрч 21%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Актив: эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл, Гонг конг 62%, Австрали 12%, АНУ 8%, Сингапур 6%, Канад 4%, БНХАУ 3%, Их Британи 2%, Швейцарь 1%, Солонгос 1%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал, Сингапур улс 21%, Гонг конг 14%, Япон улс 5%, АНУ 2%, БНХАУ 2%, бусад улс 20%, үлдсэн 42% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул аль улсын эдийн засгийн харьяат эзэмшиж буйг тодорхойлох боломжгүй байна.

Компаниудын хувьцааны үнэ

Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны үнэ 2016 оны 3-р улиралд өмнөх жилийн мөн үеийн хаалтын ханштай харьцуулахад дунджаар 39%-иар өсчээ. Тодруулбал,

Өссөн: Винсвэй Кокинг кол компаний хувьцааны үнэ 413%-иар, Монголиа Майнинг корпораци 53%-иар, Монголиан энержи корпораци 26%-иар, Тюркуойс Хилл ресурс 16%-иар, Харанга ресурс 7%-иар тус тус өссөн байна.

Буурсан: Писс мап холдинг 43%-иар, Петро матад компаний хувьцааны үнэ 34%-иар, Пропеси кол 32%-иар, Саусгови ресурс 8%-иар, Монголиа Майнинг корпорацийн хувьцааны үнэ 71%-иар, 61%-иар, Сентера Голд 5%-иар тус тус буурчээ.


Засгийн газрын бондын үнэ

2016 оны 3 дугаар улирлын сүүлчээс эхлэн дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, тэр дундаа нүүрсний үнэ эрчимтэй өсч, үүнтэй уялдан Засгийн газрын бондуудын үнэ бага зэрэг өсөлттэй байлаа. 3 дугаар улирлын байдлаарх Засгийн газрын бондуудын үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал Засгийн газрын 5 жилийн хугацаатай бондын үнэ 4.7 хувь, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэ 8.9%, Дим сам бондын үнэ 4.4%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байсан.

2016 оны 8 дугаар сарын 19 болон 26-ны өдрүүдэд S&P болон Фич зэрэг олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагууд манай улсын зээлжих зэрэглэлийг бууруулсантай холбоотойгоор Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 2016 оны 9 сарын 1-нд 9.6 хувь, 10 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 8.4 хувь хүрч өссөн (эрсдэл өсч буйг илэрхийлнэ) бол 11 дүгээр сарын 18 болон 22-ний өдрүүдэд Мүүдиз болон Фич манай улсын зээлжих зэрэглэлийг ахин бууруулснаар 11 дүгээр сарын 25 -нд ЗГ-н 5 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 11.0%, 10 жилийн хугацаатай гаргасан бондын өгөөж 9.2%-д тус тус хүрч өсөөд байна.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын позицыг тооцоолохдоо Засгийн газрын бондуудыг зах зээлийн үнэлгээгээр тооцоолон тайлант хугацаан дахь үлдэгдлийн дүнг гаргадаг бөгөөд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар Засгийн газрын 5 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 482.9 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай гаргасан бондын үнэлгээ 879.8 сая ам.доллар, Дим Сам бондын үнэлгээ 153.8 сая ам.доллар, Мазаалай бондын үнэлгээ 537.4 сая ам.доллар байна.

Дүрслэл 9. Багцын ХО-ын позиц, 2016.III* улирал, сая ам.доллар




* Урьдчилсан гүйцэтгэлээр

Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ


№	Компаний нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					9/30/2015	9/30/2016	
1	Turquoise Hill Resources	TRQ.US	US	USD	2.55	2.97	16% ▲
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.21	0.32	53% ▲
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	7.58	7.19	-5% ▼
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	2.71	2.49	-8% ▼
5	Winsway Coking Coal	1733.HK	HK	HKD	0.15	0.77	413% ▲
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.23	0.29	26% ▲
7	Petro Mатад	MATD.LN	LN	GBP	3.88	2.58	-34% ▼
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.03	-32% ▼
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.01	0.01	7% ▲
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.28	0.16	-43% ▼

Дүрслэл 10. ЗГ-н бондын үнэ, Түүхий эдийн үнийн индекс



* 2016 оны 4-р сарын 6 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.

Дүрслэл 11. МУ-н ЗГ-н бондуудын өгөөжийн муруй



* 2016 оны 4-р сарын 6 ны өдрийн үнийг суурь болгон индексүүдийг тооцов.

IV. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2016 оны 3-р улирлын байдлаар 23,785 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2,195 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 964 сая ам.доллараар нэмэгдэж 4,759 сая ам.долларт хүрсэн бол Монголбанкны гадаад өр 29 сая ам.доллараар буурч 1,729 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 1,459 сая ам.доллараар өсч 17,297 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2016 оны 3 дугаар улирлын эцэст 2,351 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9%-иар буюу 184 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 44%-ийг урт хугацаат зээл, 27%-ийг бонд, өрийн бичиг, 17%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 12%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 235.5 сая ам.долларын урт хугацаат, 79.5 сая ам.долларын богино хугацаат зээлийг шинээр авч, гэрээний дагуу 3.2 сая ам.долларын урт, 61.8 сая ам.долларын богино хугацаат зээлийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл харгалзан 1,952.8 сая ам.доллар, 398.6 сая ам.долларт тус тус хүрчээ.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2016 оны 3-р улирлын эцэст 15,046 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,065 сая ам.доллараар өссөн.

Салбарын нийт зээлийн 45% буюу 6,817 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай.

Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг авч үзвэл тайлант онд харгалзан 124 сая ам.доллар, 64 сая ам.доллар байжээ.


ААН-үүдийн экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 523 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	9/30/2015	9/30/2016	өөрчлөлт		* %2
			дүн	хувь	
Нийт гадаад өр	21,590	23,785	2,195	10%	100%
I. Засгийн газар	3,542	4,759	1,217	34%	20%
II. Төв банк	2,211	1,729	-482	-22%	7%
III. Банк	1,856	2,351	495	27%	10%
Богино хугацаат	223	399	175	79%	2%
Урт хугацаат	1,633	1,953	320	20%	8%
IV. Бусад сектор	3,510	8,128	4,618	132%	34%
Богино хугацаат	421	451	29	7%	2%
Урт хугацаат	3,088	7,677	4,589	149%	32%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	10,472	6,817	-3,654	-35%	29%

* Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр

Дүрслэл 12. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 13. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	3 дугаар улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2014	2015	2016	Дүн	2015/14	Дүн	2016/15
I. УРСГАЛ ДАНС	-462	-173	-117	289	-62%	57	-33%
Бараа ба үйлчилгээний худалдаа	-237	34	-54	272	-114%	-88	-258%
Кредит	1,707	1,382	1,395	-325	-19%	13	1%
Дebet	1,944	1,347	1,449	-597	-31%	102	8%
1. Бараа	10	98	103	87	842%	5	6%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,483	1,144	1,085	-339	-23%	-59	-5%
1.2 Импорт Ф.О.Б (debit)	1,473	1,047	982	-426	-29%	-65	-6%
2. Үйлчилгээ	-248	-63	-157	184	-74%	-94	148%
Кредит	224	237	310	14	6%	73	31%
Дebet	471	301	467	-171	-36%	166	55%
2.1 Тээвэр	-34	-15	-33	19	-55%	-17	115%
Кредит	57	68	78	11	19%	10	15%
Дebet	90	83	111	-8	-9%	28	34%
2.2 Аялал	-15	30	47	45	-301%	16	54%
Кредит	117	130	176	13	11%	46	35%
Дebet	132	100	129	-32	-25%	30	30%
2.3 Бусад үйлчилгээ	-199	-78	-171	121	-61%	-93	118%
Кредит	50	40	56	-10	-20%	16	41%
Дebet	249	118	227	-131	-53%	109	92%
3 Анхлагч орлого	-264	-250	-141	13	-5%	110	-44%
Кредит	13	17	18	4	29%	2	10%
Дebet	276	267	159	-9	-3%	-108	-41%
3.1 Ажилчдын цалин	-26	-13	-1	13	-52%	12	-93%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-238	-238	-140	0	0%	98	-41%
3.3 Бусад	-72	-103	-110	-31	43%	-7	7%
4 Хоёрлогч орлого	39	42	78	4	10%	36	84%
Кредит	90	76	101	-14	-16%	25	33%
Дebet	52	34	23	-18	-35%	-10	-31%
Үүнээс: Хувийн гуйвуулга	24	39	60	15	65%	21	54%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	48	35	27	-13	-26%	-8	-24%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт	0	0	0	0	0%	0	0%
Кредит	0	0	0	0	0%	0	0%
Дebet	0	0	0	0	0%	0	0%
2. Хөрөнгийн шилжүүлэг	48	35	27	-13	-26%	-8	-24%
Кредит	48	35	27	-12	-26%	-8	-24%
Дebet	0	0	0	0	14x	0	4%
0	0	0	0	0	0%	0	0%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-415	-138	-90	276	-67%	49	-35%
0	0	0	0	0	0%	0	0%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-823	-56	155	767	-93%	211	-377%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-823	-56	155	767	-93%	211	-377%
1. Шууд хөрөнгө оруулалт	-152	28	-60	181	-119%	-88	-312%
1.1 Актив	3	0	0	-3	-103%	0	-458%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн	3	1	0	-2	-81%	0	-37%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	-1	0	-1	166x	1	-100%
1.2 Пассив	155	-28	60	-183	-118%	89	-313%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн	12	9	0	-3	-26%	-9	-99%
1.2.2 Өрийн хэрэгсэл	142	-38	60	-180	-126%	98	-260%
2. Багцын хөрөнгө оруулалт	9	316	-4	307	36x	-320	-101%
2.1 Актив	4	5	11	1	20%	7	143%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн	2	5	1	3	170%	-4	-88%
2.1.2 Өрийн бичиг	2	0	11	-2	-107%	11	75x
2.2 Пассив	-5	-311	16	-306	63x	326	-105%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн	-3	-7	-1	-4	161%	6	-85%
2.2.2 Өрийн бичиг	-2	-304	17	-302	130x	321	-105%
2.2.2.1 Богино хугацаат	0	0	0	0	0%	0	0%
2.2.2.2 Урт хугацаат	-2	-304	17	-302	130x%	321	-105%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд	-1	0	-1	1	-136%	-1	-280%
3.1 Актив	-3	11	8	13	-529%	-3	-30%
3.2 Пассив	-1	10	8	12	-823%	-2	-20%
4. Бусад хөрөнгө оруулалт	-679	-400	220	279	-41%	621	-155%
4.1 Актив	206	6	424	-200	-97%	417	70x
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	216	3	441	-214	-99%	438	176x
4.1.3 Зээл	45	0	-3	-44	-99%	-3	-713%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт	0	0	0	0	0%	0	0%
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-55	3	-15	58	-106%	-18	-573%
4.1.5.1 Богино хугацаат	-55	3	-15	58	-106%	-18	-573%
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
4.1.5 Бусад авлага	0	0	0	0	0%	0	0%
4.2 Пассив	885	406	203	-479	-54%	-203	-50%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	341	315	29	-26	-8%	-286	-91%
4.2.3 Зээл	460	81	281	-379	-82%	201	249%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0	0%	0	0%
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	97	38	305	-59	-61%	267	701%
4.2.3.3.1 Богино хугацаат	47	-31	66	-78	-167%	97	-312%
4.2.3.3.2 Урт хугацаат	51	69	239	19	37%	170	245%
4.2.3.2 Засгийн газар	19	19	32	0	0%	13	72%
4.2.3.4 Бусад салбар	344	24	-56	-320	-93%	-80	-334%
4.2.3.4.1 Богино хугацаат	-63	-26	-56	37	-59%	-30	115%
4.2.3.4.2 Урт хугацаат	407	50	0	-357	-88%	-50	-100%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт	0	0	0	0	0%	0	0%
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	24	-78	-83	-101	-425%	-6	7%
4.2.5.1 Богино хугацаат	24	-78	-83	-101	-425%	-6	0%
4.2.5.2 Урт хугацаат	0	0	0	0	0%	0	0%
4.2.6 Бусад авлага	60	88	-24	28	47%	-112	-127%
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0	0%	0	0%
IV. Алдаа болон орхигдаулга	-237	-173	59	64	-27%	232	0%
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	172	-256	-186	-428	-249%	69	0%
1. ГВУН	163	-256	-186	-419	-256%	69	-27%
2. ОУВС-гийн зээл	-9	0	0	9	-100%	0	0%
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0	0%	0	0%

Эх сурвалж: Монголбанк

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016
Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)	-20,440	-23,689	-24,066	-24,284	-24,488	-24,701	-25,103	-25,919	-26,164
I. Гадаад актив	4,005	3,437	2,999	3,660	3,240	3,230	3,561	3,591	3,742
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	258	355	367	375	376	382	378	381	384
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	252	348	360	366	364	369	365	368	371
1.1.1 Салбар компаниас авах	252	348	360	366	364	369	365	368	371
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	6	7	7	10	12	13	13	13	13
1.2.1 Салбар компаниас авах	6	7	7	10	12	13	13	13	13
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0	0	0
2. Багцын хөрөнгө оруулалт	387	280	288	315	251	235	239	254	326
2.1 Хөрөнгийн хувьцаа	379	205	213	246	218	202	206	220	292
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.1.3 Банкууд	0	0	0	3	3	3	3	3	3
2.1.4 Бусад салбар	379	205	213	243	215	199	203	218	289
2.2 Өрийн бичиг	9	75	76	70	33	33	33	33	34
2.2.1 Бонд, үнэт цаас	0	52	52	52	15	15	15	15	16
2.2.1.1 Төвбанк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	0	0	0	0	1	1	1	1	1
2.2.1.4 Бусад салбар	0	52	52	52	14	15	15	15	15
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	8	24	24	18	18	18	18	18	18
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	8	24	24	18	18	18	18	18	18
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	9	1	2	13	8	13	9	16
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	9	1	2	13	8	13	9	16
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
4. Бусад хөрөнгө оруулалт	1,112	1,144	1,019	1,281	1,188	1,283	1,665	1,651	1,924
4.1 Худалдааны зээллэг	540	566	535	611	516	607	666	676	669
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	540	566	535	611	516	607	666	676	669
Урт хугацааны	5	4	4	5	4	4	4	5	5
Богино хугацааны	534	562	531	606	512	603	662	671	664
4.2 Зээл	5	51	51	52	53	52	64	64	53
4.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	2	49	50	50	51	51	63	63	51
Урт хугацааны	0	45	45	46	46	47	47	48	48
Богино хугацааны	2	4	4	4	4	4	16	16	3
4.2.4 Бусад салбар	3	2	2	2	2	1	1	1	1
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	3	2	2	2	2	1	1	1	1
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	567	527	433	618	619	623	935	911	1,202
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	494	315	299	430	474	441	613	587	1,005
4.3.4 Бусад салбар	73	212	134	188	146	182	323	325	197
4.4 Бусад актив	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0
5. Нөөц актив	2,248	1,650	1,324	1,686	1,413	1,323	1,265	1,297	1,092

Эх сурвалж: Монголбанк

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2012	12/31/2013	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016
II. Гадаад пассив	20,599	24,445	27,127	27,066	27,944	27,728	27,931	28,664	29,510	29,906
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	13,458	15,729	16,693	16,517	16,575	16,512	16,680	16,822	12,727	12,738
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969	5,921
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	5,101	5,388	6,078	5,989	6,059	6,040	6,004	5,972	5,969	5,921
1.2 Бусад хөрөнгө	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758	6,817
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	8,357	10,341	10,615	10,528	10,517	10,472	10,676	10,850	6,758	6,817
2. Багцын хөрөнгө оруулалт	2,689	2,470	2,913	2,906	3,590	3,043	2,961	2,975	3,634	3,690
2.1 Хөрөнгийн хувьцаа	113	35	94	87	94	82	84	76	79	72
2.1.1 Банкууд	0	0	11	11	11	11	11	11	11	11
2.1.2 Бусад салбар	113	35	83	76	83	71	73	65	68	61
2.2 Өрийн бичиг	2,576	2,435	2,819	2,819	3,496	2,961	2,877	2,899	3,555	3,617
2.2.1 Бонд, үнэт цаас	2,576	2,435	2,819	2,819	3,494	2,959	2,875	2,897	3,553	3,615
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	2,080	2,080	1,500	1,500	1,685	1,460	1,418	1,395	1,964	2,063
2.2.1.3 Банкууд	495	351	473	472	959	668	649	643	692	642
2.2.1.4 Бусад салбар	1	4	847	847	851	831	808	859	897	910
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0	0	0	0	2	2	2	2	2	2
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	0	0	0	0	2	2	2	2	2	2
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	0	12	4	6	16	13	18	13	21
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	12	4	6	16	13	18	13	21
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0
4. Бусад хөрөнгө оруулалт	4,452	6,246	7,508	7,639	7,773	8,157	8,277	8,850	13,137	13,458
4.1 Худалдааны зээллэг	252	511	594	438	538	455	470	476	539	523
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	252	511	594	438	538	455	470	476	539	523
Урт хугацааны	31	339	291	212	358	282	302	307	368	370
Богино хугацааны	221	173	303	226	180	173	167	168	171	153
4.2 Зээл	3,621	4,427	5,165	5,187	5,199	5,308	5,626	6,021	10,606	10,882
4.2.1 Төв банк	78	75	71	68	69	68	68	68	68	68
ОУВС-гийн зээл	78	75	71	68	69	68	68	68	68	68
Бусад урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742	2,696
Урт хугацааны	2,184	2,184	2,110	2,056	2,057	2,081	2,230	2,641	2,742	2,696
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	337	629	904	902	890	936	1,106	1,080	1,173	1,426
Урт хугацааны	279	429	589	611	613	713	775	727	785	1,027
Богино хугацааны	58	200	315	290	277	223	331	353	389	399
4.2.4 Бусад салбар	1,023	1,538	2,081	2,162	2,183	2,222	2,221	2,232	6,622	6,692
Урт хугацааны	735	1,305	1,822	1,901	1,912	1,976	1,982	1,994	6,333	6,397
Богино хугацааны	288	233	259	261	271	246	239	237	290	296
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	142	160	1,589	1,877	1,921	2,183	1,954	2,157	1,848	1,933
4.3.1 Төв банк	0	0	1,449	1,773	1,771	2,043	1,772	1,928	1,654	1,649
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	142	160	140	104	151	140	182	229	193	284
4.3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4 Бусад пассив	436	1,147	160	138	114	212	228	196	144	119
4.4.1 Төв банк	336	990	48	36	12	100	120	88	36	12
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	336	990	48	36	12	100	120	88	36	12
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	100	157	112	102	102	112	108	108	108	107
Урт хугацааны	100	157	112	102	102	112	108	108	108	107
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0	0	0	0

Эх сурвалж: Монголбанк

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2014	6/30/2014	9/30/2014	12/31/2014	3/31/2015	6/30/2015	9/30/2015	12/31/2015	3/31/2016	6/30/2016	9/30/2016
Засгийн газар	3,688,074	3,672,013	3,596,232	3,609,624	3,555,718	3,741,453	3,541,536	3,647,908	4,035,818	4,705,848	4,758,968
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хариццах, хадгаламж 5/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг 4/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл болон урьдчилгаа	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг 6/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	3,688,074	3,672,013	3,596,232	3,609,624	3,555,718	3,741,453	3,541,536	3,647,908	4,035,818	4,705,848	4,758,968
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хариццах, хадгаламж 5/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг 4/	1,500,016	1,500,016	1,500,015	1,500,015	1,500,015	1,684,532	1,460,040	1,417,785	1,395,244	1,963,719	2,063,466
Зээл	2,188,058	2,171,998	2,096,217	2,109,609	2,055,703	2,056,921	2,081,496	2,230,124	2,640,574	2,742,129	2,695,502
Худалдааны зээл болон урьдчилгаа											
Бусад өглөг 6/											
Төвбанк	1,041,980	1,040,319	1,434,842	1,567,579	1,876,274	1,851,339	2,211,207	1,959,643	2,084,478	1,758,003	1,729,173
Богино хугацаат	966,643	965,046	1,362,140	1,496,945	1,808,684	1,782,755	2,142,839	1,891,917	2,016,277	1,690,151	1,660,996
Хариццах, хадгаламж 5/	966,643	965,046	1,302,140	1,448,945	1,772,684	1,770,755	2,042,839	1,771,917	1,928,277	1,654,151	1,648,996
Өрийн бичиг 4/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл болон урьдчилгаа	0	0	60,000	48,000	36,000	12,000	100,000	120,000	88,000	36,000	12,000
Бусад өглөг 6/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	75,337	75,273	72,702	70,635	67,589	68,585	68,368	67,726	68,201	67,853	68,177
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	75,337	75,273	72,702	70,635	67,589	68,585	68,368	67,726	68,201	67,853	68,177
Хариццах, хадгаламж 5/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг 4/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Зээл	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл болон урьдчилгаа	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг 6/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	1,452,545	1,458,525	1,512,890	1,628,533	1,579,366	2,101,621	1,855,957	2,045,033	2,060,645	2,167,219	2,351,437
Богино хугацаат	198,301	214,573	257,890	315,015	290,182	277,023	223,244	331,388	353,322	388,534	398,599
Хариццах, хадгаламж 5/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг 4/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Зээл	198,301	214,573	257,890	315,015	290,182	277,023	223,244	331,388	353,322	388,534	398,599
Худалдааны зээл болон урьдчилгаа	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг 6/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	1,254,244	1,243,951	1,255,001	1,313,518	1,289,185	1,824,598	1,632,713	1,713,646	1,707,322	1,778,685	1,952,838
Хариццах, хадгаламж 5/	153,041	135,553	143,354	140,006	104,046	150,576	139,713	182,155	229,142	193,485	284,244
Өрийн бичиг 4/	462,381	462,965	461,099	472,617	471,741	958,609	668,437	648,790	643,258	692,444	641,643
Зээл	638,823	645,433	650,548	700,896	713,398	715,413	824,563	882,700	834,923	892,756	1,026,951
Худалдааны зээл болон урьдчилгаа	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад өглөг 6/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	3,094,162	3,040,605	3,581,504	3,521,888	3,446,135	3,574,461	3,509,863	3,501,336	3,568,258	8,060,410	8,127,860
Богино хугацаат	454,510	456,997	550,872	561,952	486,413	453,359	421,423	408,733	407,714	462,656	450,577
Хариццах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	0	0	0	0	0	1,982	1,982	1,982	1,982	1,982	1,982
Зээл	225,172	240,082	275,201	259,122	260,871	270,893	246,475	239,436	237,312	289,656	295,609
Худалдааны зээл болон урьдчилгаа	229,337	216,915	275,671	302,830	225,542	180,484	172,966	167,315	168,420	171,018	152,986
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	2,639,653	2,583,608	3,030,633	2,959,935	2,959,722	3,121,101	3,088,440	3,092,602	3,160,544	7,597,755	7,677,283
Хариццах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	877,739	885,351	860,311	846,612	846,758	851,094	830,968	808,178	858,713	896,576	910,157
Зээл	1,403,785	1,366,396	1,813,331	1,822,164	1,900,814	1,912,141	1,975,932	1,982,011	1,994,354	6,332,831	6,396,867
Худалдааны зээл болон урьдчилгаа	358,128	331,861	356,991	291,159	212,149	357,866	281,540	302,413	307,477	368,347	370,259
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын	10,665,178	10,674,498	10,825,049	10,614,673	10,527,758	10,516,524	10,471,622	10,675,547	10,849,576	6,757,621	6,817,319
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	10,665,178	10,674,498	10,825,049	10,614,673	10,527,758	10,516,524	10,471,622	10,675,547	10,849,576	6,757,621	6,817,319
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт гадаад өр	19,941,939	19,885,960	20,950,517	20,942,297	20,985,252	21,785,397	21,590,186	21,829,467	22,598,774	23,449,102	23,784,757

Эх сурвалж: Монголбанк